

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.10 дахь заалт нэмсүгэй:

“8.1.10.Өвлөх эрхийн гэрчилгээ олгохтой холбоотойгоор нотариатчийн хүсэлтийн дагуу харилцагчийн мөнгөн хөрөнгө, виртуал хөрөнгийн данс /хаяг/-ны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх.”

2 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “итгэмжлэл бүхий этгээд” гэсний дараа “, өвлөх эрхийн гэрчилгээний үндсэн дээр өвлөгч” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.6 дахь заалт нэмсүгэй:

“10.1.6.нотариатын байгууллага үйлчлүүлэгчийн хувийн байдлыг тогтоох, зайн гэрчлэлт хийх зорилгоор биометрик мэдээлэл /гарын хурууны хээ, нүүр царайны давхцахгүй өгөгдөл/-ийг.”

2 дугаар зүйл. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “болон эрх бүхий бусад” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2026 оны ... дугаар
Улаанбаатар
сарын ...-ны өдөр

хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуулийн 522 дугаар зүйлийн 522.3 дахь хэсгийн “өмчлөгч” гэснийг “өвлөгч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “эсхүл хязгаарлалттайгаар буюу нотариатчаар дамжуулан энэ хуулийн 12.7-д заасан зорилгоор хуульд заасан үндэслэл, журмын дагуу өгөх бөгөөд үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 21.2-т заасны дагуу тогтооно.” гэснийг “нотариатчид үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор энэ хуулийн 12.3.2, 12.3.3-т зааснаас бусад бүх төрлийн лавлагаа, мэдээллийг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй олгоно.” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.6.9 дэх заалт нэмсүгэй:

“10.6.9.нотариатаар гэрчлүүлсэн үл хөдлөх хөрөнгийн захиалгын гэрээ”

2 дугаар зүйл.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн “тухайн гэрээслэлийг гэрчилсэн нотариатчийн” гэснийг “Монголын Нотариатчдын танхимын” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.2.3 дахь заалт нэмсүгэй:

“27.2.3.Монголын Нотариатчдын танхимын өв залгамжлалын холбогдолтой баримтын эх хувийг -2 жил”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг